



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 08 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г Коронавируст халдвараас урьдчилан Г  
сэргийлэх зарим арга хэмжэний тухай

Улсын онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 8-ны өдрийн IX хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19) дэлхий даяар өндөр хурдацтайгаар тархаж байгаа тул гадаад улс орнуудад зорчихгүй байхыг Монгол Улсын нийт ард иргэддээ уриалсугай.

2. Монгол Улс-Япон Улс, Монгол Улс-БНСУ хоорондын болон Улаанбаатар-Эрхүү-Улаанбаатар, Улаанбаатар-Улаан-Үд-Улаанбаатар чиглэлийн олон улсын хуваарьт нислэгийг түр зогсоосон хугацааг 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрийг дуустал сунгасугай.

3. Коронавируст халдвар голомтлон тархаж буй бүс нутагт сүүлийн 14 хоногт зорчсон гадаадын иргэдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй байх, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт даалгасугай.

4. Коронавируст халдвар голомтлон гарсан улс орноос ирсэн иргэдийг тусгаарлах байранд болон гэрээр тусгаарлан ажиглах журмыг боловсруулан 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргаар батлуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд, хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хилийн зарим боомтыг түр хааж, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарласан тул Монгол Улсаас визийн хугацаандаа гарах боломжгүй болсон нь холбогдох баримтаар тогтоогдсон гадаадын иргэний визийн хугацааг сунгах асуудлыг харьяалах улстай нь харилцан адил байх зарчмыг баримтлан шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нарт даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улсын онцгой комиссын “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2020 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 2 дугаар тогтоолын 2 дахь заалт, “Зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх, зарим хязгаарлалтын арга хэмжээ авах тухай” 2020 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 3 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН